



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

НИЙСЛЭЛИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗРЫН 2025 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН
ТАЙЛАН

АУДИТЫН КОД: НТАГ-2026/278/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер: Х.Түвшинбаяр
Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Отгонбаяр
Утас: 315558 Цахим хаяг: otgonbayarda@audit.gov.mn
Ахлах аудитор: М.Ундармаа
Утас: 325093 Цахим хаяг: undarmaam@audit.gov.mn
Аудитор: Ө.Цог-Өрнөх
Утас: 325093 Цахим хаяг: tsog-urnukhu@audit.gov.mn

Улаанбаатар хот
2026 он

Утас: +976 70007734
Факс: +976 70007734

Цахим шуудан: ub@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

Хаяг: Нийслэлийн өмчийн нэгдүгээр байр,
Ерөнхий сайд Амарын гудамж, Сүхбаатар
дүүрэг Улаанбаатар-15160, Монгол Улс

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	9
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	9
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	10
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал.....	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.5 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	15
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	16

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НА	Нотлох ажил
НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөн, Г.Сорюк, 3 даяар,
Утас: 7000 7734, Факс: (076-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

№ 2025-00-05 /059
Тайлан № _____ Т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Хяналт шалгалтын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь

НИЙСЛЭЛИЙН ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
С.ЭНХБАЯР ТАНАА

14200750219

харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудал

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 бүлэг, 35 зорилтын хүрээнд 85 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 88 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	134,507,850.00	210,531,271.38
33	АВЛАГА	0.00	50,936,966.38
335	Бусад авлага	0.00	50,936,966.38
3351	Байгууллагаас авах авлага		12,035,647.38
3352	Хувь хүмүүсээс авах авлага		38,901,319.00
34	УРЬДЧИЛГАА	83,090,000.00	0.00
34600	Урьдчилж гарсан зардал	83,090,000.00	
35	БАРАА МАТЕРИАЛ	51,417,850.00	159,594,305.00
351	Түүхий эд материал	30,326,990.00	0.00
35110	Тусгай зориулалттай материал	30,326,990.00	
354	Хангамжийн материал	21,090,860.00	159,594,305.00
35410	Бичиг хэргийн материал	1,523,060.00	2,342,179.00
35420	Аж ахуйн материал	707,900.00	14,277,900.00
35430	Сэлбэг хэрэгсэл		5,842,720.00
35440	Түлш, шатах тослох материал	3,735,000.00	620,000.00
35470	Бусад хангамжийн материал	15,124,900.00	136,511,506.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	495,959,420.15	994,666,286.66
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	495,959,420.15	994,666,286.66
392	Биет хөрөнгө	495,959,420.15	967,423,026.68
39203	Авто-тээврийн хэрэгсэл	132,250,000.00	132,250,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-82,406,770.02	-103,031,249.78
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	647,996,543.20	820,913,851.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-349,629,692.93	-239,469,069.51
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	141,313,768.21	356,330,443.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-33,414,428.31	-26,104,281.31
39214	Бусад үндсэн хөрөнгө	39,850,000.00	39,850,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл		-13,316,666.72
393	Биет бус хөрөнгө	0.00	27,243,259.98
39301	Програм хангамж	1,430,000.00	31,149,920.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,430,000.00	-3,906,660.02
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	630,467,270.15	1,205,197,558.04
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	630,467,270.15	1,205,197,558.04
51	Засгийн газрын хувь оролцоо	630,467,270.15	1,205,197,558.04
512	Хуримтлагдсан үр дүн	630,467,270.15	1,205,197,558.04
51210	Өмнөх үеийн үр дүн	630,467,270.15	630,467,270.15
51220	Тайлант үеийн үр дүн		574,730,287.89
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	630,467,270.15	1,205,197,558.04

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	0.00	3,960,103,643.76
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	419,704,270.00
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	419,704,270.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	419,704,270.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		419,704,270.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	0.00	3,540,399,373.76
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	232,392,538.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		232,392,538.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	0.00	3,308,006,835.76
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/		3,308,006,835.76
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	0.00	3,372,251,534.03
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	3,372,251,534.03
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	3,358,651,534.03
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	2,509,934,361.90
210101	Үндсэн цалин		1,358,845,269.32
210102	Нэмэгдэл		444,183,663.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		514,160,962.00
210104	Урамшуулал		192,744,467.58
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	311,525,463.48
210201	Тэтгэврийн даатгал		214,687,082.73
210202	Тэтгэмжийн даатгал		24,992,739.40
210203	ҮОМШӨ-ний даатгал		12,569,489.14
210204	Ажилгүйдлийн даатгал		11,754,497.72
210205	Эрүүл мэндийн даатгал		47,521,654.49
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	29,071,680.00
210304	Байрны түрээс		29,071,680.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	85,868,071.00
210401	Бичиг хэрэг		24,231,114.00
210402	Тээвэр, шатахуун		37,060,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		11,392,878.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		13,014,179.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		169,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	9,150,210.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		345,000.00
210604	Урсгал засвар		8,805,210.00
2107	Томиллолт, зочны зардал	0.00	105,323,400.00
210701	Гадаад албан томиллолт		104,062,600.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		1,260,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	74,045,004.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		66,431,970.00
210803	Даатгалын үйлчилгээ		823,172.00

210804	Тээврийн хэрэгслийн татвар		942,312.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо		99,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		3,190,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		2,558,550.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	233,733,343.65
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		51,650,642.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		33,133,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		148,949,601.65
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	13,600,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	13,600,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		13,600,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	0.00	587,852,109.73
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	13,121,821.84
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		13,121,821.84
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	0.00	-13,121,821.84
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	0.00	574,730,287.89

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	0.00	3,540,399,373.76
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	0.00	3,540,399,373.76
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	232,392,538.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		232,392,538.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	0.00	3,308,006,835.76
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/		3,308,006,835.76
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	0.00	3,309,325,353.76
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	3,309,325,353.76
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	3,256,824,034.76
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	2,521,970,009.28
210101	Үндсэн цалин		1,370,880,916.70
210102	Нэмэгдэл		444,183,663.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		514,160,962.00
210104	Урамшуулал		192,744,467.58
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	311,525,463.48
210201	Тэтгэврийн даатгал		214,687,082.73
210202	Тэтгэмжийн даатгал		24,992,739.40
210203	ҮОМШӨ-ний даатгал		12,569,489.14
210204	Ажилгүйдлийн даатгал		11,754,497.72
210205	Эрүүл мэндийн даатгал		47,521,654.49
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	29,071,680.00
210304	Байрны түрээс		29,071,680.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	76,945,516.00
210401	Бичиг хэрэг		19,539,743.00
210402	Тээвэр, шатахуун		32,745,000.00

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		11,392,878.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		13,267,895.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	74,337,930.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		24,704,100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		39,045,300.00
210604	Урсгал засвар		10,588,530.00
2107	Томилолт, зочны зардал	0.00	105,323,400.00
210701	Гадаад албан томилолт		104,062,600.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		1,260,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	78,842,784.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		66,431,970.00
210803	Даатгалын үйлчилгээ		823,172.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		942,312.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо		99,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		3,190,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		7,356,330.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	58,807,252.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		22,729,352.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		36,077,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	52,501,319.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	52,501,319.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		38,901,319.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		13,600,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	0.00	231,074,020.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	0.00	231,074,020.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	231,074,020.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	231,074,020.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		231,074,020.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	0.00	-231,074,020.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл		630,467,270.15		630,467,270.15
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	630,467,270.15	0.00	630,467,270.15
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	630,467,270.15	0.00	630,467,270.15
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	630,467,270.15	0.00	630,467,270.15
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	630,467,270.15	0.00	630,467,270.15
D08	Тайлант үеийн үр дүн		574,730,287.89		574,730,287.89
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	1,205,197,558.04	0.00	1,205,197,558.04

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгаар болсон

Итгэргөөр!

Үзүүлэлт	Тайлант оны			
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,182,123,200.00	3,308,006,835.80	874,116,364.20	79.1
УРСГАЛ ЗАРДАЛ	4,182,123,200.00	3,308,006,835.80	874,116,364.20	79.1
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,953,515,600.00	3,255,505,516.80	698,010,083.20	82.3
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,073,268,500.00	2,521,970,009.30	551,298,490.70	82.1
Үндсэн цалин	1,521,203,200.00	1,370,880,916.70	150,322,283.30	90.1
Нэмэгдэл	629,492,600.00	444,183,663.00	185,308,937.00	70.6
Унаа хоолны хөнгөлөлт	813,120,000.00	514,160,962.00	298,959,038.00	63.2
Урамшуулал	109,452,700.00	192,744,467.60	-83,291,767.60	176.1
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	442,514,900.00	311,525,463.50	130,989,436.50	70.4
Тэтгэврийн даатгал	300,910,100.00	214,687,082.70	86,223,017.30	71.3
Тэтгэмжийн даатгал	35,401,200.00	24,992,739.40	10,408,460.60	70.6
ҮОМШӨ-ний даатгал	17,700,600.00	12,569,489.10	5,131,110.90	71.0
Ажилгүйдлийн даатгал	17,700,600.00	11,754,497.70	5,946,102.30	66.4
Эрүүл мэндийн даатгал	70,802,400.00	47,521,654.50	23,280,745.50	67.1
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,742,100.00	29,071,680.00	6,670,420.00	81.3
Байрны түрээс	35,742,100.00	29,071,680.00	6,670,420.00	81.3
Хангамж, бараа материалын зардал	69,763,600.00	64,653,148.00	5,110,452.00	92.7
Бичиг хэрэг	11,618,600.00	13,907,375.00	-2,288,775.00	119.7
Тээвэр, шатахуун	29,519,300.00	25,665,000.00	3,854,300.00	86.9
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,590,000.00	11,392,878.00	-802,878.00	107.6
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	18,035,700.00	13,687,895.00	4,347,805.00	75.9
Эд хогшил, урсгал засварын зардал	267,612,900.00	264,972,030.00	2,640,870.00	99.0
Багаж, техник, хэрэгсэл	191,039,200.00	191,039,100.00	100.00	100.0
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	40,587,600.00	40,587,500.00	100.00	100.0
Урсгал засвар	35,986,100.00	33,345,430.00	2,640,670.00	92.7
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,186,600.00	12,410,814.00	775,786.00	94.1
Даатгалын үйлчилгээ	827,700.00	823,172.00	4,528.00	99.5
Тээврийн хэрэгслийн татавар	958,800.00	942,312.00	16,488.00	98.3
Тээврийн хэрэгслийн оношилгоо	760,000.00	99,000.00	661,000.00	13.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,190,100.00	3,190,000.00	100.00	100.0
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	7,450,000.00	7,356,330.00	93,670.00	98.7
Бараа үйлчилгээний бусад зардал	51,427,000.00	50,902,372.00	524,628.00	99.0
Бараа үйлчилгээний бусад зардал	32,900,000.00	32,550,472.00	349,528.00	98.9
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	18,527,000.00	18,351,900.00	175,100.00	99.1
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	228,607,600.00	52,501,319.00	176,106,281.00	23.0
Бусад урсгал шилжүүлэг	228,607,600.00	52,501,319.00	176,106,281.00	23.0
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	39,000,000.00	38,901,319.00	98,681.00	99.7
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	189,607,600.00	13,600,000.00	176,007,600.00	7.2
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,182,123,200.00	3,308,006,835.80	874,116,364.20	79.1
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	4,182,123,200.00	3,308,006,835.80	874,116,364.20	79.1
Орон нутгийн төсвөөс	4,182,123,200.00	3,308,006,835.80	874,116,364.20	79.1

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгаар болсон

Итгэргөөр!

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	232,392,538.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	232,392,538.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	232,392,538.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,712,368.00
210401	Бичиг хэрэг	5,632,368.00
210402	Тээвэр, шатахуун	7,080,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,000,000.00
210602	Тавилга	18,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	105,323,400.00
210701	Гадаад албан томилолт	104,062,600.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	1,260,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	66,431,970.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	66,431,970.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	29,924,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,198,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	17,726,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	232,392,538.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	232,392,538.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	232,392,538.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Нийслэлийн Хяналт шалгалтын газар нь Монгол Улсын хууль, тогтоомж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, нийгэм эдийн засгийн зорилтууд, Нийслэлийн хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлого, Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг даргаас хот байгуулалт, барилга, дэд бүтцийн салбар дахь төрийн хяналт шалгалтын талаар баримтлах бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах үндсэн чиг үүрэг бүхий Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг юм.

Нийслэлийн хяналт шалгалтын газар нь Нийслэлийн иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах зорилгоор барилга, дэд бүтцийн бүтээн байгуулалтад холбогдох стандарт, норм, дүрмийн мөрдөлтийг хангуулж, төрийн хяналт шалгалтын үр нөлөөг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Энэ хүрээнд төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг сургалт, арга зүй, мэдээллээр хангах замаар хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг сайжруулах зорилтыг дэвшүүлэн ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт гарчээ. Үүнд:

- Монгол Улсын 2025 оны төсвийн тухай;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай;
- Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулиуд;
- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоол “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн батлах тухай”;
- Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 05 албан даалгавар “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай”;
- Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаал “Журам шинэчлэн батлах тухай”.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нийслэлийн Хяналт шалгалтын газрын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нийслэлийн Хяналт Шалгалтын газар нь Хотын стандартын аюулгүй байдлын хяналт зохицуулалтын газрын даргын 2022 оны А/09 дугаар тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Нийслэлийн Хяналт Шалгалтын газрын 2025 оны санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод дараах өөрчлөлтөрсөн байна. Үүнд:

- Сангийн сайдын А/03 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”;

- Сангийн сайдын 112 дугаар тушаалаар баталсан “Төсвийн зарим ангилал шинэчлэн батлах тухай”;

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааны бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 574,730.3 мянган төгрөгөөр буюу 91,2 хувиар өссөн нь тайлант үеийн үр дүн өссөнтэй холбоотой байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	-	50,937.0	50,937.0
Урьдчилгаа	83,090.0		-
Бараа материал	51,417.9	159,594.3	108,176.5
Үндсэн хөрөнгө	495,959.4	994,666.3	498,706.9
Нийт хөрөнгө	630,467.3	1,205,197.6	574,730.3
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	630,467.3	1,205,197.6	574,730.3
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	630,467.3	1,205,197.6	574,730.3

Дээрх хүснэгтээс харахад өмнө оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урьдчилгаа, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн данс байна.

Авлага дансны үлдэгдэл 50,937.0 мянган төгрөг байгаа нь Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 4,223.3 мянган төгрөг, Хувь хүний орлогын албан татварын авлага 7,812.2 мянган төгрөг, шүүхийн шийдвэрийн дагуу нэг удаагийн тэтгэмжийн зардлаас олгосон нөхөн төлбөрийн 38,936.9 мянган төгрөгийг тус тус авлагаар бүртгэсэнтэй холбоотой байна.

Тайлант оны эхэнд урьдчилгаа дансанд бүртгэлтэй байсан 83,090.0 мянган төгрөгийн урьдчилгаагаар “Амно Фейшн” ХХК, “Промакс” ХХК-иудаас хөдөлмөр хамгааллын зориулалттай бараа материал авч зориулалтын дагуу зарцуулсан байна.

Тайлант хугацаанд бараа материалын дансны үлдэгдэл нийт 159,594.3 мянган төгрөг байгаа бөгөөд үүнээс бичиг хэрэг 2,342.1 мянган төгрөг, сэлбэг хэрэгсэл 5,842.7 мянган төгрөг, түлш, тослох материал 620.0 мянган төгрөг, аж ахуйн материал 14,277.9 мянган төгрөг, бусад хангамжийн материал 136,511.5 мянган төгрөгийг тус тус эзэлж байна.

Бараа материал өмнөх оноос 108,176.5 мянган төгрөгөөр өссөн нь бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс буюу хяналт шалгалтын багаж, өвөл зуны ажлын хувцас, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны хэрэгсэл худалдан авсантай холбоотой байна. Бараа материалын үлдэгдэлд шаардлага хангахгүй, хэрэгцээгүй бараа материал байхгүй байна.

Нийслэлийн хяналт шалгалтын газар нь төсвийн хөрөнгөөр сургалтын тавилга, эд хогшил, хиймэл оюун ухаанд суурилсан өгөгдөл боловсруулах программ хангамж, сургалт болон хяналт шалгалтын тоног төхөөрөмж зэрэг нийт 231,074.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдан авч, холбогдох анхан шатны баримт, шийдвэрийг үндэслэн данс бүртгэлд тусгасан байна. Мөн 2024 онд урьдчилан гарсан зардлаар 10,000.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг тайлант хугацаанд орлогод авч бүртгэсэн байна.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас үнэ төлбөргүй шилжүүлэн авсан суурин болон зөөврийн компьютер, олон үйлдэлт принтер, албан тасалгааны тавилга, эд хогшил зэрэг нийт 419,704.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг холбогдох тушаал, шийдвэрийг үндэслэн орлогод авсан байна.

Мөн элэгдлийн зардлаараа анхны өртөгөө нөхсөн, эвдэрч ашиглах боломжгүй болсон 159 нэр төрлийн 243,918,8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг Нийслэлийн өмчийн харилцааны газрын хурлын шийдвэрийн дагуу, Хяналт шалгалтын газрын даргын А/21 дугаар тушаалыг үндэслэн акталж, данс бүртгэлээс хассан байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар цэвэр хөрөнгө өмчийн дүн өмнөх оноос 574,730.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үйл ажиллагааны үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 5,627,062.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 1,202,204.1 мянган төгрөгөөр бууруулж, 4,424,858.1 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 242,734.9 мянган төгрөгөөр бууруулж тодотгосон нь Ерөнхий сайдын “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай” 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 05 дугаар албан даалгаврыг хэрэгжүүлэхтэй холбоотой байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр 4,182,123.2 мянган төгрөгийг тодотголоор баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 3,308,006.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 3,308,006.8 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,308,006.8 мянган төгрөг буюу 79,2 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлаас 551,298.4 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас 176,106.2 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 130,989.4 мянган төгрөгийг тус тус дутуу зарцуулан нь голлон нөлөөлсөн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70417- Хяналт шалгалтын газар				
1.1	80801-Үндсэн үйл ажиллагаа	4,182,123.2	3,308,006.8	874,116.4	

1.2	80802- ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	22,000.0	13,600.0	8,400.0	79,2%
1.3	80829- Шүүхийн шийдвэрийн дагуу иргэдэд олгох төлбөр	39,000.0	38,901.3	98.7	

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нийслэлийн Хяналт шалгалтын газрын нэмэлт санхүүжилтийн дансаар Нийслэлийн Засаг даргын А/33, А/391 дугаар захирамж, “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах Нийслэлийн салбар зөвлөл”-ийн А/52 дугаар тушаалаар нийт 232,392.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, 232,392.5 мянган төгрөгийг захирамжид тусгасан зориулалтын дагуу зарцуулсан байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, нийт 253,337.4 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө гаргаж, төлөвлөгөөний дагуу худалдан авалт хийсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Нийслэлийн Хяналт Шалгалтын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Санхүүгийн аудитын албаны ахлах аудитор М.Ундармаа, аудитор Ө.Цог-Өрнөх нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Отгонбаяр, санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер Х.Түвшинбаяр, тэргүүлэх аудитор Г.Нандинжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Нийслэлийн Хяналт шалгалтын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Нийслэл дэх Төрийн аудитын газарт 2026 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 01/98 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр

дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны нийт хөрөнгийн 2,551,125.2 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 38,266.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага нь зардлыг хэмнэх арга хэмжээ авч үндсэн үйл ажиллагааны зардал, хангамж, бараа материалын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал, урсгал шилжүүлэгийн зардлаас нийт 874,116.3 мянган төгрөгийн хэмнэлт бий болгожээ.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 4 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийслэлийн Шүүхийн шинжилгээний газар нь 2025 онд нийт 22,674,830.0 мянган төгрөгийн 228 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод мэдээлэхээс хугацаандаа бүрэн байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалттай, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон зөрчлийг давтан гаргахгүй байх 747,245.7 мянган төгрөгийн 5 зөвлөмж, 77,492.2 мянган төгрөгийн 2 албан шаардлага бүрэн хэрэгжсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	77,492.2	2	77,492.2	100
Зөвлөмж	5	747,245.7	5	747,245.7	100
Нийт дүн	7	824,737.9	7	824,737.9	100

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой нийт 50,936.9 мянган төгрөгийн 1 алдаа¹ илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

- НДШ, ХХОАТ-ийн илүү төлөлтийн 12,035.6 мянган төгрөгийг тайлагнаагүйг;
- Шүүхийн шийдвэрийн дагуу ажилгүй байсан хугацааны цалин хөлс, нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын шимтгэлд нийт 38,901.3 мянган төгрөгийг төсвөөс төлж, буруутай этгээдээс авах авлагаар бүртгээгүйг;

Энэ нь “УСНББОУС 29 Санхүүгийн хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт, НББОУС 39 Санхүүгийн хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байсныг аудитын явцад залруулсан.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс Залруулсан	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Санхүүгийн тайланд авлагыг орхигдуулж тусгасан	1	50,936.9	1	50,936.9			1
Дүн	1	50,936.9	1	50,936.9			1	50,936.9